



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар A/731

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06/02 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Хүүхдийн ордон”-д тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зардалд 23,000,000 (хорин гурван сая) төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосугай.

2. Дээрх 23,000,000 (хорин гурван сая) төгрөгийг аймгийн үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлаар хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ж.Энх-Амар)-т шилжүүлсүгэй.

4. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ж.Энх-Амар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101594

D:My Doc. Zahiramj. Zasag darga